

ТҮҮХТ ХҮМҮҮС

**Б. БУЯНЧУУЛГАНЫ ТУХАЙ
АРХИВЫН ШИНЭ
МАТЕРИАЛ-ТУСГАЙ
ДААЛГАВАР БИЕЛҮҮЛСЭН НЬ**

Бид нэрт түүхч, дипломат, манжич Б. Буянчуулганы тухай бичих санаа төрж, олон газрын архив шүүрдэн үзэж байхад, ШУХ-д ажиллаж байх үеийн түүний анкетад цэргийн хэрэглэгдэхүүн авах ажлаар нэг удаа Бээжин, Тянжин, хотуудаар явж байсан гэж бий. Гэтэл Архивт хадгалагдаж буй энэ тухайд өөрийнх нь бичсэн замын тэмдэглэлээс үзэхэд явсан зорилго нь арай өөр бололтой.

1923 онд ардын засгийг түлхэн унагаах зорилготой Сэцэн хан аймгийн Ачит вангийн хошууны бичээч Цэрэнпил нарын үүсэл хуйвалдаан гарч ихээхэн нүргээнтэй явдал болжээ. 1920-иод оны эхээр энэхүү хуйвалдаан шинээр тогтсон ардын засагт ихээхэн халтай байсныг жан жин Д.Сүхбаатар өвчтэй байхдаа «Манай хэрэг юу болж буй, гудамжаар юу сонсогдоно. Би санаагаа их зовж байна. Өнөөх Цэрэн пилийн этгээд нар цагаан сараар дашрамдуулан хорлох болов уу? хэмээн ихэд сэжиглэнэ» гэж хэлж байснаас тодорхой. Бидний бодоход Буянчуулганы эцсийн зорилго нь ардын засгийг устгахын тулд япон, хятадаас тусламж гуйхаар одсон Цэрэнпил нарын хойноос тэдний үйл ажиллагааг тагнан зогсоох юм уу, үнэн зөв учрыг олох, тэдний буруутай үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор явсан бололтой. Энэ үйл ажиллагаанд хятад газар нутгийн байдал, хэл заншлыг сайн мэдэх, нөгөө талаар хувьсгалаас өмнө ар, өвөр монголчуудыг нэгтгэн хамгаалж авах талаар орос улс ямар бодолтой байгааг мэдэх даалгаврыг¹ удаа дараа биелүүлж байсан Буянчуулган мэтийн дадлага туршлага бүхий хүн л заншлан тагнах ажлыг гүйцэтгэхэд тохирох байсан болов уу? Буянчуулган энэ удаагийн явалтаараа эдний толгойлогч Цэрэнпил нэгэнт хятад газар очоод үхсэн, тэдний үйл ажиллагаа төдийлөн бүтэлтэй болоогүй улс төрийн шалтгаануудыг тогтоож Цэвээнноровын хамсаатан этгээдүүд Их хүрээнд хэн хэн байдгийг тогтоож, тэрээр тэндээ байж үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд мухардмал байдалд орсон нөхцөлд их хүрээнд буцаж очиход ихээхэн зовлонтой байгааг ойлгож, даруйхан Их хүрээнд буруугаа хүлээгээд очвол бас ч юу юугүй алчихгүй болов уу гэдгийг түүнд ойлгуулсан бололтой.

Дашрамд өгүүлэхэд БНМАУ-ын түүхийн гутгаар ботид бичээч Цэрэнпил, Цэвээнноров нарын хуйвалдааныг өөр өөр хэрэг болгон бичсэн нь ташаа бололтой. Харин ч бичээч Цэрэнпилийг хятадад нас барсны дараа Цэвээнноров өөрийгөө Цэрэнпил хэмээн нэрийдэж ажиллагаагаа үргэлжлүүлжээ.

Олон зүйл нуршин судлаач, уншигч таныг чилээсэнд хүлцэл өчиж, урьд өмнө гараагүй архивийн нэгэн баримтыг та бүхний мэргэн оюунд бүрэн эхээр нь толилуулсу.

* * *

Арван дөрөвдүгээр он цагаан сарын арван хоёронд Чуулалт хаалганы газраа хүрч гүн Буянчуулган Тай шинтай Люю Гүн хэмээх Дэнд буугаад тэндээс эд нараас салах ба дэнгийн хөлс бага, гарч У тайн Ганжуур сүмийн гавьж хэмээх Дандараар газарчлуулан Дин Гуан Юн хэмээх дэнд шилжин буусан тэнд Дандараас түүний бадарыг дагуулан Бадарын хэрэг хэлэлцэж байсан ба тэнд 6 хоноод галт тэр гэнд суун Тэ түгт У тайн умба нартай очиж нэг хоноод тэндээс Тай

рээг хэмээх дэнд бууж гурав хоноод түүн дотор хүнтэй хэлэлцсэн Санд мөн дэнд мөргөлөөр ирсэн монголчууд хошууны лам Лувсан нарын хоёр хүнтэй нэр нутгийг асуулцсаны сүүлд тэднээс надад хэлсэн нь таны тэр газраас төр ямар байна. Богдын эрх ямар байна. Богдын дэргэд байсан дагина үхсэн хэмээсэн түүний оронд хүн залсан уу хэмээсэнд миний хэлсэн нь Богдод эрх мэдэл бий. Дэргэд нь бас нэг дагина залсан хэмээсэнд түүний хэлсэн нь: Сонсвоос Богдод эрх мэдэлгүй ба танай газрыг улаан орос эрхийг эзэлчихүй хэмээмой. хэмээн сонссон. Бас хэлсэн нь, миний сонсохуйд танай монголын нэгэн хүнийг хятадын зуун хүн боловч дийлэхгүй учир монгол хүмүүс энэ нутгийн хаагуур ч сэлгүүцэж явахуйд эрхтэй хэмээсэнд миний хэлсэн нь Та юу хэлнэ вэ? Манай Монгол болвоос эрдэм чадалгүй нэгэн хэсэг хөдөөх болхи улс яахин тийнхүү хэлж болно, хэмээсэнд түүний хэлсэн нь, энэ нь тиймгүй танай монголын тийнхүү хүч нь Богдын тарнийн явдал бүхий одоо харин Богдыг эрх мэдэлгүй болгосон болвоос манай хятад дийлэх буюу хэмээн хэлэлцмүй хэмээн хэлсэнд бас танай монголд машины зэрэг боловсорсон улсын эдлэлээс байна уу хэмээн асууж хэлэлцсэнээс өөр юм хэлэлцсэнгүй. Тэнд гурав хоноод мөн Минибадарын оронд мөргөж мөн орноос мөнгө нэхэхээр ирсэн Чин түй тан хэмээх Төрбат хэл нэвтрэлцэх ийм хүн байна хэмээн дам сонсоод мөн оронд очиж түүний биетэй учирч энгийн үг хэлэлцэхийн улмаас өөрийн бие Бээжин орох учраа хэлж түүний биеийг хамтаар явж болно уу хэмээсэнд уг Төрбат дуртай зөвшөөрөн хамтаар явахаар тогтож мөн урьд танайх У Тайн засаг ламын Шанзуб Пинтэй учирч түүгээр уламжлан засаг ламд мөргөж яваа учраа айлтгасанд тэр ламаас хэлсэн нь Хүрээнд цаг төр сайн байна уу, Богдын Лүндэн тэгш үү, хувраг олноор харшлах зүйлгүй сайн сууж байна уу хэмээсэнд, миний хэлсэн нь, цаг төрийн байр тогтмол сайхан болов, Богдын Лүндэн тэгш бөгөөд олон хувраг бүгдээрт гачигдах зүйлгүй байна хэмээсэнд түүний хэлсэн нь, манай энд сонсохуйд тэнд байгаа улаан намын орос болвоос хурал номын хэргийг тасалдуулан сан жасаас алба авдаг Богдод эрх мэдэлгүйгээс гадна зоог гүн цэгийг хасдаг хэмээмүй энэ нь худал хэлэлцэж болно, үгүй болбоос сайн хэмээн хэлсэнд би буцаж мөн Шанзубын гэрт орж ирсэнд түүнээс намайг юунд ийнхүү их удав хэмээсэнд би эл учрыг хэлсэнд түүний хэлсэн нь, харин таныг монгол төвдийг оруулж авна хэмээн хүмүүс явсан хэмээдэг үнэн үү гэсэнд би сонссонгүй хэмээж учир юуг асууваас түүний хэлсэн нь, Үнэн гэнэ лээ, тавь жаран хүн тэмээ худалдан авч ноднин өвлийн тэргүүн сард явсан учир тэр үед тэмээ их үнэтэй болсон хэмээн хүрээнээс бичиг ирсэн гэж над нэгэн орос бичиж үзүүлж чи сонссонгүй буй за. Ер нь танай монгол зарим нь улаан засгийг устгах хэмээн Мүгдэн, Харбинаар яваа хэмээх ба бас зарим нь энэ засгаа бататгаж төвдийг оруулж авахаар явахыг үзвээс монгол үнэхээр учиргүй байна. Үүний дотор дурдсан засгаа устгах хэмээсэн Цэрэнпил, Дугартан Мүгдэн, Харбинаар явж хэрэг нь бүтээгүй хэмээн сонсогдсон харин Найман ван тэднийг баахан тусалж буй за хэмээхээс гадна эд нарын дотроос Цэрэнпил нь манай Утай дээр ирсэн одоо буцсан буй за хэмээсэнд би түүнээс салж Халхын лам Дамчаа хэмээх Ишжамц, Буянданзан нартай учирч, яваа учрыг хэлж тэдний гэрт очиж энгийн хэлэлцээрийн улмаас тэдний хэлсэн нь -Чи Цэвээнноровыг таних уу хэмээсэнд, би түүнийг таних мэт байж чухам аль хошууны ямар хүн хэмээсэнд, тэд нарын хэлсэн нь энэ Цэвээнноров болвоос Сэцэн хан аймгийн хуучин Санбээс Засгийн хошууны захирагч Минжүүрийн хөвгүүн энэ нь угаас баян хүний хөвгүүн бөгөөд худалдаа наймаа их хийдэг, үүнийг би танина энэ нь улаан зас-

гийг устгахаар хятадын олон хотоор явж хэргээ бүтээгээгүй манай энд мөргөлөөр л сарын хуучдаар ирээд цагаан сарын аравдаар явсан чи харин энэ мэт явж чаддаггүй юм уу хэмээсэнд би тэд нарыг таних мэт байж хэлсэн нь та тийм хэрэггүй үг битгий хэл энэ хүмүүс хэргээ эс бүтээсэн аваас хүрээнд очиж болдоггүй юм уу, чухам хятад хүмүүс яваа хэмээсэнд тэр Дамчаа хэмээх Ишжамцын хэлсэн үг эд нар дөрвөн хүн яваа боловч Цэвээнноров ганцаараа энд ирээд манай эндээс нэгэн хэлмэрч дагуулж у Пэй Фү-тэй учирна хэмээн энэ цагаан сарын 11-нд явсан хэмээсэнд мөн Буянданзангийн хэлсэн нь ийм хэрэггүй юм хэлэлцэх хэрэггүй хэмээн хэлэлцсэнийг нь зогсоож энгийн үг хэлэлцэн байгаад тархаж өөрийн сууж буй оронд очиж Төрбаттай учран энгийн үг хэлэлцэхийн улмаас Мэргэн вангийн хошууны Туваан, галдаа мөргөлөөр У тайд сууж буйг мэдэж түүнтэй учран энгийн үг хэлэлцсэн боловч ноцтой зүйл гарсангүй ба бас Бинт вангийн хошууны Ловоронд суусан нэгэн өвгөн ламын Шанзуб ирж үүний дээр хэлэлцсэн засаг ламын нэгэн адил үг асууж байгаад сүүлд Монголын засгийн газраас манай өвөрлөгчийн хүмүүсээс албан хааж байгаа хүмүүс байна уу хэмээсэнд миний хэлсэн нь мөн ч цөөхөнгүй амой. Чухам хэн хэнийг мэдэхгүй хэмээсэнд түүний хэлсэн нь үүний урьд болбоос монгол хэмээхийг гагцхүү халх бас бусад нь бус хэмээх бололтой байсан учир эдүгээ өөр монголын зэрэг хүмүүсийг төдий л их тушаал хүлээлгэн албан хаалгасангүй буй за хэмээсэнд ми ний хэлсэн үг урьд засгийн үед болбоос тийм байсан эдүгээ болбоос тиймгүй манай монгол язгууртан бүгдээр найрамдан дотночлох ба гадначлахгүй нэгэн санаагаар засгийн хэргийг явуулах мэт ба өвөр лөгчийн хүмүүсээс бас ч ихээхэн тушаалыг хүлээж албан хаасан хүмүүс байна хэмээсэнд түүний хэлсэн нь, Тийм үү, манай газрын олон ноёдын хэлэлцэх болбоос үүний урьд Бинт ванг хүрээний газраа очиход хорлосон хэмээн хэлэлцдэгийг ер нь энэ ардын засаг мандах цаг болжээ хэмээн хэлэн ахуйд мөн Төрбат ирж энгийн үг гурвуул хэлэлцэн байгаад тархаж мөн Төрбаттай маргааш Бээжинд явахаар хэлэлцэн тогтож миний хэлсэн нь би Намхай, Будлан, Мүгдэн, Махагал хоёрт мөргөлөөр явах боловч хань олдохгүй болов уу хэмээсэнд түүний хэлсэн нь Мүгдэнд танай Монголын дөрвөн хүмүүс буй хэмээсэнд ямар хүнийг асууваас түүний хэлэх нь -Чи ахаасаа битгий нуу. Чи лавтай тэд нарын тухай хүн буй за энэ үгийг замд хэлэлцье. Гагцхүү явах явдлаа төхөөр хэмээн хэлсэнд би зөвшөөж маргааш нь илжиг унаж зам явж энгийн үг хэлэлцэн байгаад миний хэлсэн нь чиний урьд хэлсэн дөрвөн хүн хэмээх нь ямар янзын хүн ямар хэргийн учир явж амой хэмээсэнд түүний хэлсэн нь, Чи мэдсээр битгий асуу, чи түүн дотор таних хүн байна уу хэмээсэнд би хэлсэн нь надад та них хүн байхгүй байваас нэг хүн байж мэднэ үүний дотор учир бол воос надтай урьд сайхан танилцсан нэгэн дүү гэнэт мэдээ чимээгүй одсон нь түүн дотор байж магадгүй хэмээн асууж байхаас гадна түүний биеийг урагш явсан мэт сонсогдох тул тэд нарыг асуумуй түүний нэрийг би саяын таны хэлсэн эдгээрийн нэрийг гаргаж хэлбээс сая хэлмүй хэмээсэнд түүний хэлсэн нь -Би тэд нарын нэрийг мэдэхгүй, сая тэд нар минь нэгэн журмын дүүг Бээжин дээрээс авч явсан тэр минь дүү болбоос аливаа мэдсэн явдал би надаас нуухгүй хэлэлц дэг юм хэмээн энгийн үг хэлэлцэн явсаар дэнгийн газраа очоод мөн хэлэлцэхийн улмаас Төрбатын надад хэлсэн нь миний сонссонд Бээжинд ноднин өвлийн сүүл сард нэг дөрвөн монгол хүн ирж энгийн хүмүүстэй учрах үгүй ба өдөр олон хүмүүс буй газраар явахгүй тийм

хүмүүс ирээд түүний доторхи нэгний хэлэх нь би ардын намд нэг дүүгээ алуулсан тул өшөө заналаа энэ ардын засгийг устгахаар хүрээнээс гарсан тул зорьсон хэргийг эс бүтээхийн инар эргэж харихгүй хэмээн хэлж байгаа хэмээн миний журмын дүү хэлсэн хэмээх ба тэн дээс Бээжин хүрээд Төрбат бээр түүний дүү хэмээхийн бие эгж ирэх эсэхийн чимээг асуулгасанд ер ирэх чимээгүй хэмээн хэлсэн ба түүний сүүлд Төрбатын надад дахин хэлсэн нь миний дүүг тэд нарын хамт ирэх учир хоёр удаа захиа өгсөн боловч байгаа газраа хэлсэн гүй хэмээхээс жич сонсох нь Чжин Зо Линий Зүүн этгээд ууланд оршсон хулгай нараас 40-өөд хүмүүс Бээжинд ирж одоо дөрвөн хүн үлдээд байгаа үүний дотор надад сайн таних нэг хүн бий, энэ нь чиний явдалтай тохирох хүн буй за би учруулсугай хэмээсэнд миний хэлсэн нь ямар үг хэлж ямар хүнтэй учруулах хэмээж байгаа хэмээсэнд түүний хэлсэн нь чи лавтай тэр монголын хятад хүнтэй учрах хэрэгтэй хүн буй заа. Би чамайг энэ дөрвөн хүнтэй учруулъя. Энэ хүмүүс чинь тэр явдлыг мэдэж мэднэ хэмээн түүнийг ирж нэлээд өдөр саатаад эс олж мөн Төрбатад энэхүү миний сурвалжилсан монголын дөрвөн хүн энэ хир ирж дав дув учирахгүй болсон учир энгийн хэлж байхуйд Төрбатын надад хэлсэн нь тэд нар лав тамгагүй учир ийнхүү их удсан буй за. Тиймгүй аваас Чжан Зо Лин яахин ийнхүү их удаамуй, чи тэд нарыг ирэхээс өмнө эргэж Богдын тамгатай бичиг нэгийг олж ирвээс тэд нараас түргэн бид нарын хэрэг бүтмүй хэмээснээс гадна энэ үгийг мөн ч түүний бие тухай бүр дурсч хэлж байсан ба тэд нарыг эс олж мөн Төрбатад чиний дүү тэр монголын дөрвөн хүнийг хамтаар ирвээс надад бичиг өгөөрэй. Би Жан шян го-д очоод ирсүгэй хэмээн хэлээд мөн Жан шян го-д бага хэрэгтэй ирээд байтал Төрбатаас бичиг өгсөнд би эргэж Бээжинд очиж уулзваас түүний хэлэх нь, миний дүү монголын дөрвөн хүн ирээгүй боловч бидний үүний дээр ирж байсан Тайваны дөрвөн хүний нэг нь байгаа газрыг би олж чиний учрыг хэлбээс тэр чамтай учрахыг хүсэх тул би чамд бичиг өгөх буй хэмээсэнд би Төрбатыг явуулж мөн тэр хүнийг Төрбатын гэрт авчирч мэнд амарыг асуун байхад Төрбатаас бид хоёрын хооронд танилцуулан өгч хэл нэвтрүүлэн хэлэлцүүлсэнд мөн Тайваны хэсгийн тэргүүлэгч Дотоод Монголын Сүн овогт Төмөрийн хэлсэн нь та ямар хэргээр хэдэн хүн хааш яваа буй хэмээсэнд би хэлсэн нь би анх мөргөлөөр яваа боловч манай монголоос хувьс галын хэргээр явсан хэдэн хүмүүс зүүн тийш сонсогдох тул тэд нарын учир явдлыг дуулж сонсохыг хүссэн учрыг Төрбатад хэлсэнд таныг Зүүн зүгийн явдлыг мэдэх магадгүй хэмээн танилцуулан өгсөн болой хэмээсэнд түүний хэлсэн үг-Та чухам ямар хэрэг зорилготой яваа, би болвоос улаантай уулзваас улаан, цагаантай уулзваас цагаан би угаас ууланд сууж улсаас урвасан хүн болох тул аль хүчирхэг улсад түшиглэнэ хэмээсэнд миний хэлсэн нь би тухайлан тийм хэмээх явдалгүй би зүгээр тэд нартай учрахыг хүссэн хүн болой хэмээсэнд түүний хэлсэн нь тэд нартай уулзаж болно, тэд нар болбоос Мүгдэнгийн Гао ча нан хэмээх галт тэрэгний станцын дэргэд Во чи хэмээх япон дэнд сууж байна. Тэд нарын хэрэг нь төдий л бүтээгүй буй за. Та тэдэнтэй уулзах чухам ямар хэрэг байна. Таних хүн бий буюу хэмээсэнд миний хэлсэн нь уулзваас байх эсэхийг болзошгүй түүн дотроос нэг хүн тийм нэртэй хүн байх үгүйг сонсч ирээрэй хэмээн над захисан нь би танд түүний нэрийг хэлвээс хойт өдөр нутаг газар хариад ялтай хэрэг гарах болой. Гагцхүү манай ах Төрбатын гаргаж хэлсэн хүмүүс болмогц танд ийнхүү үг аюумшиггүй хэлмүй хэмээсэнд түүний хэлсэн нь улаан оросыг гаргахуйд маш хялбар тэр улстай ч

болно, үгүй ч болно хэмээгээд энгийн үг хэлэлцэхийн улам түүний хэлэх нь би урьд монголын газраа тайж Тогтох ба Насантогтох эд нартай удаа дараа явж ирсэн цэрэгтэй дайралдан ер дийлэгдэн явсан удаагүй Хүрээнд Төмөр хэмээвээс олон хүн мэднэ Насантогтох ба тайж Тогтохын гэрийн хүмүүсийг асууж сайхан найртай хэмээн хэлсэнд би хэлсэн нь Таны байж байгаа уул нь ямар нэртэй газар хэмээсэнд Гуандун нутгийн зүүн этгээдэд хэмээсэнд би асуусан нь Та анх хэдүйд гарсан Тайваны тэргүүлэгчийн нэр хожим захиа бичиг нэвтрүүлбээс хаагуур дамжуулан явуулах зэрэг учрыг асуусанд түүний хэлсэн нь -Тэргүүлэгч хүмүүсийн нэр болвоос миний нэрээр хэлбээс болно. Би бусад нөхөдтэйгээ зөвчилвөөс хэрэг бүр бүтнэ. Тэд болбоос надаас урьдын Тайванд очсон. Би тэд нартай хожим нийлсэн минь харьяат захиргааны цэрэг босвоос одоо бэлхэн буй нь түм илүү өөрийн нутагтаа үйлдвэр зэрэг би хийж буй нь хоёр түм гаруй бүгд цэрэг нийлээд арван гурван түмээд байна. Бичиг үсэг нэвтрүүлбээс энэхүү Төрбатаар нэвтрүүлнэ. Үүгээр нэвтрүүлээгүй хэргийг бидний хоёр этгээд авч хэлэлцэхгүй хэмээн энгийн үг хэлэлцэн байж тараад маргааш нь мөн өөрийн нөхөр нэгэн хүнийг дагуулан ирж та хоёр хэлэлц хэмээсэнд би түүнийг нэр зэргийг асууваас тэр миний нэр Арслан хэмээдэг урьд би монголын Хүрээ газраа цөөхөн сар байсан хэмээн энгийн үг хэлэлцэн байгаад түүний хэлсэн нь одоо Хүрээ болбоос ямар засаг явуулж байна монгол өөр дотроо мэдэж байна уу, орос мэдэж байна уу хэмээсэнд би хэлсэн нь чухам мэдлийг өөрсдөө мэдэж байна. Мөн ч элдэв мэдэхгүй хэргийг болвоос оросоор яаравчлан байх тул орос бас мэдмүй. Энэ засгийг болвоос бид нарын дотроос зарим нь дуртай, зарим нь дургүй тийн хэмээвч бүгдээр дуртай хэмээн хэлэхгүй хэмээсэнд түүний хэлсэн нь дургүй нь юунд дургүй баймуй хэмээсэнд миний хэлсэн нь урьд урьдын хаад улсыг зассан нь нь буруу зүйл байна уу хэмээсэнд түүнийг хэлсэн нь Та юу хэлж байна. Одоо Хаант засаг мандуулан огт бүтэхгүй хэмээсэнд би та юу хэлж байна хэмээсэнд түүний хэлсэн нь урьд урьдын хаад болбоос ноёдоо жинс зэрэг эд мөнгөөр хууран тэд нарын гарт бидний этгээдийг барьж гашуун зовлонг амсуулжээ. Хянаваас ер эртнээс эхлэн эдүгээ хүртэл хаант засгийн үед ардын эрх хэмээх зүйл байсангүйгээс гадна тэр дунд манай Монголд хаант засаг байгуулаад онц тусгүй харин та хаант засаг хүсч яваа болбол би тантай хэлэлцэхгүй хэмээсэнд миний хэлсэн нь таны хэлэх үгэнд ардын засгийн явдал их л тохирмуй энэ санааг та сая мэдсэн үү эрт мэдсэн үү хэмээсэнд түүнийг хэлсэн нь би багаас ноёндоо их дарлагдсан ба үүний урьд бидний зуугаад хүмүүс тус нутагт ардын засгийг байгуулахыг эрмэлзсэн ер нь ардын засгийг байгуулахад энэ ноёдыг алахаас өөр болохгүй хэмээсэнд би хэлсэн нь та хоёр тийм санаатай болбоос надад зураг ба саналаа бичиж өгсүгэй би уламжлан гол засгийн газраа албан хаах этгээдэд нэвтэлгэн өгье хэмээсэнд тэд нар даруй зөвшөөрөн зураг ба бичгийг өгч салснаас гадна тэдний хэлэх нь бидний Тайван нар болбоос энэ хир Чжан Зо Линд багтаж буй боловч тэр бид нарт цалин аму хэрэглэл, мөнгө өгсөнгүй гагцхүү хэлэх нь та нар монголын газраа орж улаан цэргийг хөөж монголыг авбаас монголын эрхийг та нарт өгмүй хэмээсэн үүнд бид нарын биеэс тус Тайфунгийн газраас төлөөлөгч болон Бээжинд ирээд У Пэй фү, Та Сүндүн, Шу Гүн нарт бид нарт зэвсэг мөнгө үлэмж хэсгийг тусал, бид нар Чжан Золинтой сэтгэл санаа тохирохгүй учир цаанаас нь Чжан Золинг цохиж дайралдсугай хэмээн бичиг өгсөнд Та Шүндүн, Шу Гүн, У Пэй фү нар зөвшөөрч бичиг өгөөд

зэвсэг мөнгө өгөх билет бичгийг аваад зохих газраа очимуй. Энэ баримт ийнхүү явсан зорилго болвоос эд нарт ийм үг үсэгтэй бичиг өргөж зэвсэг мөнгө үлэмжхэнийг аваад гэдрэг У Пэй фү-тай туслалцах гол санаа амуй бас зохих нь бид нар алиныг ч өмнөөс зааврыг хүлээж монгол газраа цэрэг хөдөлгөх магадгүй үүнд бид нар нэгэн үндэстний монгол хүмүүс болох тул бидний санаа хэзээд монголд элэгтэй тул эртнээс бичиг захиа нэвтрэлцэж байваас хожмын хэрэгт сайн болохыг мэдэгдье, хэмээсэн бас энэ хоёрын дахин хэлсэн нь, Бид хоёртой улс төрийн хэрэг нэвтрэлцье хэмээвээс бид хоёрын зургийг захианы хамтаар мөн Төрбат бээр дамжуулан учирч элдэвийг нэвтрэлцье хэмээн хэлэлцэн тараагаад буцаж явахыг завдан байтал өнөөх У тай дээр учирч танилцсан Халхын лам Дамчаа хэмээх Ишжамц, Буянданзан нартай хоолны пүүсэнд учирч энгийн үг хэлэлцэн байхын улмаас миний асуусан нь үүний урьд асууж байсан Цэвээнноров, Дугартан эдүгээ байна уу хэмээсэнд Дамчаа хэмээх Ишжамцаас түрүүлэн хэлсэн нь Цэвээнноров энд ирж гэнээ учирьяа хэмээвэс болох бизээ хэмээсэнд би хэлсэн нь Та ирсүгэй над түүний байдаг газрыг олж өгнө үү хэмээсэнд чингэсүгэй хэмээн маргааш мөн дэнд учрахаар хэлэлцэн тогтож тараад мөн маргааш нь би очиж асууваас тэр Цэвээнноров нь Сүн шин дэнд буй гэнэ хэмээсэнд би хэлсэн нь та очиж түүнд чи надаас бүү цээрлэ би харш үгүй, харштай хэмээвээс энэ газраа чамайг би хэрхмүй. Хэрэв сэжиглэвээс миний биеийг далдаас ч болов хар, эрхбиш учрахыг хүсмүй хэмээн уламжлан хэлж над лугаа уулзуулмуй би таныг буусан дэнд очиж хүлээсүгэй та очиж түүний биеийг авч ирж надад уулзуулмуй хэмээсэнд тэр даруй зөвшөөрөн явсан ба би түүнийг буусан дэнд хүлээн хаалга дээр нь зогсож байтал мөн Ишжамц өнөөх Цэвээнноров хэмээх хүнийг дагуулан ирсэнд нь Цэвээнноровт хэлсэн нь чи сайн явж байна уу хэмээсэнд Цэвээнноров ийн хэлсэн нь би сайн явж байна хэмээсэнд бид хоёр чиний пүүснээ очиж цөөхөн үг хэлэлцсүгэй хэмээн Цэвээнноровтой бид хоёр Ишжамцаас салж нэгэн цайны пүүсэнд орж цай уун энгийн үг хэлэлцэхийн улмаас миний хэлсэн нь хэрэг чинь бүтэж явна уу зоос мөнгөөр хир дутаж явна өөрсдийн чинь бие мэнд сайн явна уу хэмээсэнд Цэвээнноровын хэлсэн нь -Явдал ч бүтсэн зүйлгүй. Зоос мөнгөөр ч энэ хир гачигдсангүй байна. Та ямар хэргээр хэдэн хүний хамт энд ирсэн нутаг газраа нэр хэн хэмжээсэнд би түүнд нутаг газраа Гандан дээр суудаг Хүрээнээс нэгдүгээр, У тайд-мөргөх, хоёрдугаар ганжуурын цаас авахаар ганцаар ирсэн хэмээсэнд түүний хэлсэн нь Гандан дээр суудаг Андуу-нарын аймгийн Чимэддорж гэдэг хүнийг танимуй хэмээсэнд би танимуй хэмээсэнд түүний хэлсэн нь: -Тэр хэдий хир насны ямар ажил хийдэг хүн одоо хир хүрээнд байна уу хэмээсэнд би түүний зүсийг үзсэн тул зүй зохисыг харж тохируулан хэлээд үүний урьд миний бие хүрээнд өвчтэй байсан тул энэ хир чухам буй үгүйг мэдсэнгүй хэмээсэнд түүний хэлсэн нь тэр хүн ноднин намрын хирд байсан уу үгүй юу хэмээсэнд би хэлсэн нь, чухам байсан үгүй мэдэхгүй хэмээн энгийн үг хэлэлцэн байж одоо бие угаадаг газраа очиж тавтай хэлэлцсүгэй хэмээн гараад нэгэн усны газраа очоод түүний надад хэлсэн нь одоо чи над үнэн учир явдлаа хэл би тийм хүнд гэм хийх хүн биш хэмээсэнд миний түүнд хэлсэн нь над тийм гойд учир явдалгүй бид үнэнээ хэлж байна хэмээсэнд түүний надад хэлсэн нь -Чи япон Данзан хэмээдэг хүн биш үү хэмээсэнд би биш хэмээсэнд түүний надад хэлсэн нь энэ япон Данзан гэдэг хүн чухам ямар янзын дүрстэй хүн хэмээсэнд миний хэлсэн нь Япон Данзан болбоос

эр дундын настай түвшин царай бүхий хүн хэмээсэнд түүний надад хэлсэн нь япон Данзан гэдэг энэ хир энд байна уу, тэр надтай уулзах хэмээн явна хэмээн сонсогосныг би болбоос түүнтэй уулзах юмсан хэмээн бодсон тэр энэ газраа надтай уулзаад яах билээ хэмээсэнд би хэлсэн нь тэр учрыг чухам би мэдсэнгүй дээ. Намайг тэр япон Данзан лугаа адил бүү бод, тэр болбоос ёстой ардын намын хүн, үеийн нөхөр би асуух зэргээр уулзсан хэмээсэнд түүний хэлсэн нь чиний улаан намын хүн мөн, бишийг эс мэдэв, мөн ч атугай, бус ч атугай хамаагүй ер нь би чамтай нэг явсан явдлаа гүйцэд ярьсугай хэмээсэнд миний хэлсэн нь энэ нь зүйтэй бид хоёр хоорондоо сэжиг таавар авах явдалгүй хэмээсэнд түүний хэлсэн нь - Уржнан жилийн зун цагт Маймаагаар миний бие Манжуур зэргийн газраа худалдаагаар очоод байтал надтай Цэрэнпил хэмээх хүн учирч хэлсэн нь би дээд газраас улаан оросыг устган монголын хуучин засгийг мандуулах тухай Богдын тамгат бичиг Угтамын хувилгаан ламтай учирч ирснээс гадна мөн чиний нэр энэ бичигт оролцсон ба мөн хувилгаан ламаас чамайг чанагш хамтаар яв хэмээснээс гадна эс итгэвээс үүнийг үзүүл хэмээн санг үзвээс хүзүүндээ зүүсэн чулууг өгсөнийг үзвээс үүний урьд хувилгаан багшаас миний гуйж байсан чулуу мөн болох тул их л итгэмжлэн санаж уг худалдааны мөнгөө энэ хэрэгсэл зардалдаа хэрэгсэж мөн Цэрэнпил, Цэвэг, Зоригт, Гомбо нартай хамтаар Харбин дайраад Мүгдэнд очиж мөн Цэрэнпил цэцэг өвчнөөр бие барсан учир түүний бие нэр бичгийн тэргүүнд орсон тул би биеэ Цэрэнпил хэмээн хэлэн мөн тамгат бичгийн нэгийг японы нийслэл Дун гун хотын Монголын эрх хэргийг эрхлэх түшмэлд бариад бас нэгийг Чжан Зо Линд барьсан мөн бусдын хамт Мүгдэнд ирээд Манжуураас урагш газраас даруйхан хурдан морь Бадам, Санж, Даржаа нараар дамжуулан аваачиж Шанхай зэрэг газраа худалдуулан мөнгийг аваад мөн Мүгдэнг дайрч Амбан хотноо ирж буцаж харихыг завдан байтал мөн дамжуулан байсан Бадам нараас ардын намаас Угтамын хувилгаан ламын зэрэг арван хэдэн хүнийг олж Цэрэнпил нарын хамт дөрвөн хүнийг хаа үзэгдсэн газраа ол хэмээн бичиг тарааж явна хэмээн хэлснийг сонсоод Хүрээ орохыг байж ардын намд улмаар өшөөрөн цааш уг барьсан бичгээ зохих газруудаас шаардан нэхэмжилсээр эдүгээ хүрч мөн нөхөд нар өөдлөшгүй тэнэг этгээд болох тул тэд нартай миний бие завсар эвдрэлцэж тэдний этгээд намайг салах хэмээхүйд би сэмхэнээ оргож энд ирээд уг хэрэг бүтэх үгүйг өөрийн бие лавтай мэдэх боловч өнөө маргаашийн хоолны хэдэн зоосонд шамдаж бусад нөхөд Жан Золин япон нартай түүгээр хуйвалдсан учир санал тохирохгүй салж ирвэй хэмээн уг бичгийн хариуг дахин бичгээр У Пэй, фү, Шу Гүн нараас шаардан нэхэмжилсэн баймой хэмээн мөн энгийн үг хэлэлцэж байж миний хэлсэн нь энэ шөнө 11 цаг болж миний сууж байгаа газраас хол бөгөөд ийнхүү шөнө хөлсний тэрэг ховор танд таних дэн байна уу, очиж хэлэлцэн хоносугай хэмээсэнд түүний хэлсэн нь миний таних Сүн Шин хэмээх нэгэн дэн буй чи тэнд ороод хүрээний хүн хэмээн битгий хэл би чамайг У тайн хүн хэмээн хэлсүгэй тэнд нэг монгол хүн бий хэмээсэнд миний хэлсэн нь болно хэмээгээд хоёул тэр дэнд орж үзвээс нэгэн хуучны байртай гуч хирийн настай нэгэн монгол хүн байх бөгөөд Цэвээнноровыг их л хүндэлсэн мэт суудал зайлан өгөв. Тэнд бид хоёр цай авч ирүүлэн, энгийн хэлэлцэн байж үзвээс мөн Цэвээнноровын сууж буй гэр мэт их л гэр шиг байсан ба миний хэлсэн нь Мүгдэнд байгаа дөрвөн хүний хийж буй хэрэг ямархан байна хэмээсэнд, түүний хэлсэн нь тэр дөрвөн мал чухам улс

төрийн хэрэг хийх ч байтугай зөвхөн идэж уухаа чадахгүй амьтад үүнийг урьд Японы Дун Шин хотод гүрний их хэрэг болоход бид дөрвийг асуугаад та дөрөв дотор гүрнийн хэргийг хэлэлцвээс сайн хүн нэг байна хэмээн намайг зааж хэлээд бусдыг ...юу ч болов хэмээн хэлсэн хэмээсэнд би хэлсэн нь тийм боловч таныг үүсвэрлэн хийсэн хэрэг байваас тэд нар тэр хэргийг мөрдөн хөтөлбөрлөвөөс ямар ч хэрэг бүтээж чадах биз хэмээсэнд түүний хэлсэн нь тийм хэрэг буй боловч тэд нар энэ хир завсартаа эв үгүй бөгөөд энэ хэргийг анх хийхүйд Цэрэнпилийн нэрээр миний зүс (бас) очиж хэрэг болох тул тэд нар дангаар хэрэг хийж чадахгүй буй за хэмээн санамуй хэмээсэнд миний хэлсэн нь-Таны хэлсэн Чимэддорж хэмээх хүн аль зэргийн ухаантай хүн, тэр энэ зэрэг хэрэгт явж чадах хүн юм уу анх энэ хүн хэнээс заавартай ямар хүн явуулсан хэмээхэд түүний хэлсэн нь тэр бас надаас доор хүн их ууртай бөгөөд гоёмсог. Санаа үл тохирвоос зодолдомуй хэмээхийн зэргэлдээгээр асуусан нь: -Та номчийн аймгийн Гэлэнхүү гавьжийг таних уу хэмээсэнд миний хэлсэн нь-Түүний зүсийг үзвээс би танимуй, урьд нэрийг сонссон хэмээгээд түүний хэлсэн нь -Сономжуравын Пэдгэр хэмээх нэгэн шадар хүн буй хэмээгээд та тэр Пэдгэр, Гэлэнхүү гавж хоёрыг таних уу хэмээсэнд түүний хэлсэн нь би танихгүй, тэр Чимэддоржтой ихэд найртай хүмүүс хэмээн мөн Чимэддорж над хэлсэн хэмээн хэлэлцэн тэр шөнө унтаад маргаашийн орой Цэвээнноровын надад хэлсэн нь та лав улааны нэгэн хүн чухам хэнтэй хэдүүлэн ямар хэргээр ирсэн чухам учир явдал үнэнээ муу нөхөртөө хэлсүгэй хэмээсэнд миний хэлсэн нь би тантай анх учирснаас эхлэн ер худал хэлсэнгүй эс үнэмшсэнээс миний буусан газраа очиж явсан явдал уулзсан хүнийг муулан үз хэмээсэнд түүний хэлсэн нь би нөхрийн үгийг ер үл үнэмших газаргүй гагцхүү сая төлөв талбиулбаас таныг их тустай хүн баймой хэмээв хэмээсэнд миний хэлсэн нь та битгий сэтгэлээ самууруул, санасан зорилгоо сэндэлж ийш тийш дэмий бодох хэрэггүй хэмээсэнд түүний хэлсэн нь би одоо амь гарах арга байна уу намайг очвоос Богдод айлтгаж алах болов уу хэмээсэнд миний хэлсэн нь сонсвоос алах хүнийг Богдод айлтгаж бурхан дэлгэж алмуй хэмээн сонссон. Ер нь та бурууг хүлээж шууд биеэ хүргэж очоод явсан учраа нэгд нэгэнгүй хэлж энэ засагт бие хөрөнгө хайрлалгүй зүтгэхийг хүсмүй хэмээвээс ялд хагацах учир байх бизээ хэмээн хэлсэнд түүний хэлсэн нь чи ардын намын мэдэлтэй хүн таних аваас над уулзуулан өгч болно уу би уулзваас хэлэлцэх учиртай үг нэлээд байна. Бас одоо би очъё хэмээхүйд тэд нар манай ардын намын сүлд ийм хэцүү үүний толгойг эргүүлэн ирэв хэмээх болов уу хэмээсэнд миний хэлсэн нь чи битгий хэл тийм үг хэлэн хөөрөв эс хөөрөв гайгүй чи гагцхүү амь гарваас барав хэрэв чи эс итгэвээс Гүнбэн, Лаврин, У тай зэрэг газраар мөргөл хийж явбаас чамайг ардын нам хэрхмүй. Чи ийм болохгүй хэргийг дэмий л сахиж суугаад юу хиймүй хэмээсэнд түүний хэлэх нь би одоо Хүрээ ороод буудуулан үхэхэд таван махбодь хямрах их зовлон байна уу хэмээсэнд би хэлсэн нь тийм зовлон ирэхгүй түүнээс чи бүү зов. Цаазны үхэл хэмээгч бодол бүхий хүнд сайн үхэл. Чи харин эс уулзваас хэдэн өдөр хоригдож байгаад их л нарийн албаны хүн болно хэмээн учирлан хэлснээс гадна үүний дээр дурдсан хэргийг би одоо хүрээнд ороод ардын намын ихээхэн алба хаадаг хүнд хэлж өгье миний бие ирвээс нэг сар дотор ирмүй хэмээсэнд түүний хэлсэн нь энэ дөрвөн

сарын 20 хүртэл би энд чамайг хүлээж Зүүн тийш хэргийг тагнаж суусугай. Чамайг эс ирвээс би энэ улс төрийн хэргийг нэлээд эрт огт орхисон хүн болох тул мөргөлөөр бус тийш явна. Ер нь миний байгаа талаас монголд гэм учир гарахгүй харин Япон ба Жан Золин нараас гэм учир Монголд гарах магадгүй чингэвээс харин юу ч аргалахгүй болох биз ээ хэмээхээс гадна түүний хэлэх үгний дотор явсан хэрэг хүчин төгөлдөргүй болж эгж Нийслэлийн газраа ирэхийг үнэхээрийн их бодовч ноогдох ялаас айн эрмэлзэж байх мэт... хэмээх үүнийг БХЯ-ны цэргийн Төв архиваас бүрэн эхээр нь авсан болой.

А. Дашдэмбэрэл, Б. Даваасүрэн

1 НАХЯ-ны архивын фонд № 1-ээс